

**АЖ ҮЙЛДЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-16</i>
<hr/>	
<i>1. Байнгын хорооны даргыг сонгох тухай</i>	<i>3-16</i>

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы  
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны  
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 22 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Ц.Даваасүрэн, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа.

**Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл нар Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарыг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Д.Энхтүвшин, Д.Батбаяр, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Д.Энхтуяа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, Б.Пунсалмаа, Ж.Золжаргал, Г.Очирбат, Д.Батбаяр нар үг хэлэв.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа санал хураалтын төхөөрөмж сааталтай байгаа тул санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

**С.Одонтуяа:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 0  
Бүгд: 15  
100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

**С.Одонтуяа:** Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 0  
Бүгд: 15  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 58 минут үргэлжилж, 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 80.9 хувийн ирцтэйгээр 10 цаг 20 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ОДОНТУЯА

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,  
09 цаг 22 минут

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**С.Одонтуяа:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 62 хувьтай бүрдсэн тул Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр танилцуулна.

Өнөөдрийн хуралдаанд ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Далайн Батбаяр 5 дугаар тойрог ирсэн байна. Дамбын Батлут 4 дүгээр тойрог, Сайнхүүгийн Ганбаатар 1 дүгээр тойрог, Пүрэвжавын Ганзориг жагсаалт, Цэрэнпилийн Даваасүрэн 4, Хажекберийн Жангабыл 3 дугаар тойрог, Жаргалсайханы Золжаргал 9, Ганзоригийн Лувсанжамц жагсаалт, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан 7, Пүрэвбаатарын Мөнхтулга 1, Салдангийн Одонтуяа жагсаалт, Мөнхтулга ирээгүй байгаа шүү. Ганбатын Очирбат жагсаалт, Буяагийн Тулга 5 дугаар тойрог ирсэн байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа 4, Доржзодовын Энхтуяа жагсаалт, Дашицэрэнгийн Энхтүвшин жагсаалт, Мөнхчулууны Энхцэцэг жагсаалт. Эдгээр хүмүүс хуралдаанд оролцож байна. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх

асуудлыг танилцуулъя. Пунсалмаа ирчихсэн үү. Бадамдоржийн Пунсалмаа ирсэн байна. Жагсаалт. Нэр нь дурдагдаагүй хүн байхгүй байна.

**Хэлэлцэх асуудал. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай.**

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу. Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудлаа баталлаа.

Байнгын хорооны даргад нэр дэвшигчийн танилцуулгыг Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар танилцуулна. Бас Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл орж ирэх юм байна.

Өнгөрсөн парламентаар шинээр байгуулагдсан байнгын хорооны 1 бол энэ Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо байгаа. Тэгэхээр харьцангуй бас шинэ Байнгын хороо гэсэн үг. Одоо нөгөө бусад Байнгын хороод бас хуралдаад, тэгээд бүлгийн дарга нар орж, Байнгын хороод дээр бас танилцуулаад байх шиг байна. Тэгэхээр жоохон хүлээж байгаарай гэсэн. Бүлгийн даргад нэр дэвших хүнийг ерөнхийдөө эхний удаа бол намын бүлгүүд зөвшилцөөд, хүнээ санал болгож байх шиг байна лээ. Байнгын хороо дээр бас энэ намын бүлгүүдэд дарга нарыг бас санал болгож байх шиг байна лээ. Жишээлэхэд, тийм тийм байнгын хороон дээр Монгол Ардын намын хүнийг ч гэдэг юм уу, Ардчилсан намын ч гэдэг юм уу тийм зөвшилцлүүд хийгдсэн байх.

Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар гишүүн орж ирлээ. Мөн Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл нар хуралдаанд Байнгын хорооны даргад нэр дэвшигчийг танилцуулна. Танилцуулгаа эхэлье.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны гишүүдийн амрыг эрье.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан парламент үйл ажиллагаагаа эхэлж байна. Ингээд Байнгын хороодын удирдлагыг сонгох үйл ажиллагаа бас энэ өдрүүдэд явагдаж байна. Энд бол Улсын Их Хурлын удирдлага, парламентад суудалтай намуудын удирдлагын зөвшилцсөний үндсэн дээр ард иргэдийн өгсөн санал, парламентад эзэлж байгаа суудалтай холбогдуулаад Байнгын хороодын даргын асуудлыг тодорхой хэмжээнд бас хуваарилах нь зүйтэй юм. Хамтраад энэ дээр ажиллаад явах нь зүйтэй гэсэн ийм шийдлийг гаргасан байгаа. Ийм учраас Монгол Ардын нам б байнгын хороонд нэр дэвшүүлэх, Ардчилсан намы 3 байнгын хороонд, ХҮН нам 2 байнгын хороонд нэр дэвшүүлэхээр удирдлагын түвшинд тохиролцсон байгаа. Үүний дагуу Аж үйлдвэржилтийн байнгын хорооны даргад Ардчилсан намаас нэр дэвшүүлэхээр бид бас тохирсон юм. Тийм учраас Ардчилсан намаас энэ Байнгын хорооны даргад нэр дэвшүүлнэ. Үүнийг дэмжиж өгөхийг гишүүдээсээ хүсье.

**С.Одонтуяа:** Мөнхбаатар даргад баярлалаа. Одоо Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** Байнгын хорооны хуралдааныг даргалагч болон эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд Ардчилсан намын бүлгээс нэр дэвшүүлж байгаа Сайнхүүгийн Ганбаатар гишүүний танилцуулгыг та бүхэнд хүргэе.

Боловсрол эзэмисэн байдлын хувьд:

1985 онд Дархан хотын 10 жилийн дунд сургуулийг, 1988 онд Баянхонгор аймгийн 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийг, 1988-1989 онд МУИС-ийн Германы инженерийн бэлтгэлд сурсан. 1989-1991 онд Политехникийн дээд сургуульд суралцсан. 1991-1993 онд ЗХУ-

ын Новосибирск хотын Геодези, цахилгаан, техник уул уурхайн дээд сургуульд суралцсан. 2010 онд Хөдөлмөрийн дээд сургуульд Хөдөлмөрийн эдийн засагч, Эдийн засгийн ухааны магистр зэрэг эзэмшижээ.

Ажилласан байдлын хувьд:

2001-2002 онд Хаан банкны Тусгай активын газрын захирал, 2002-2003 онд СЭЗДС-д багш, 2003-2005 онд Удирдлагын академид багш, 2004-2005 онд Улсын Их Хурлын даргын Нийгэм, эдийн засгийн бодлогын зөвлөхөөр, 2007-2012 онд МҮЭХ-ны ерөнхийлөгч, БСШУ-ы ҮЭХ-ны даргаар, 2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр, 2020-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Та бүхэн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа Сайнхүүгийн Ганбаатар гишүүнийг бас дэмжиж өгөхийг хүсье.

**С.Одонтуяа:** Цогтгэрэл даргад баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.1-д Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлнэ гэж заасан. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүн байна уу. Алга байна. Нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу. 3 гишүүн Лувсанжамц, Батбаяр, Энхтүвшин, Мөнхбаясгалан 4 гишүүнээр тасаллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-д Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно гэж заасан. 9.5.1 гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт

асууж, тайлбар авах гэж заасан. Ингээд асуулттай гишүүд асуултаа эхэлье. Лувсанжамц асуултаа асууна.

**Г.Лувсанжамц:** Сайн байцгаана уу. Ганбаатар гишүүнээс асуулт байна. Аж үйлдвэржилтийн бодлогод чухал 3 зүйлүүд байгаа гэж бодож байна. 1 дүгээрт дэд бүтэц, 2 дугаарт боловсон хүчин, 3-д нь инновац гэж бодож байна. Тэгээд мөн салбар тус бүрээр жишигээлбэл, хөдөө аж ахуй, эсвэл хүнд үйлдвэр ч байдаг юм уу эсвэл жижиг дундаас хүнд гээд 3 төрлөөр бас өөр өөр бодлогууд хэрэгжүүлэх ёстой болов уу гэж бодож байна. Та Байнгын хорооны дарга болоод эдгээр асуудал дээр яаж, ямар бодлого барьж, ямар байдлаар зохицуулалттай ажиллах вэ.

2 дугаар асуулт нь болохоор Аж үйлдвэрийн бодлого бол бусад Байнгын хороо, бусад яамдуудтай нягт уялдаатай ажиллах нэн шаардлагатай. Ялангуяа хот байгуулалт, дэд бүтэц, эрчим хүч гэсэн. Тэдгээр байгууллагууд, төрийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах вэ. Энэ тал дээр өөрийнхөө ажлын төлөвлөгөө юм уу төсөөлөл байвал хэлж өгнө үү. Баярлалаа.

**С.Одонтуяа:** С.Ганбаатар гишүүн хариулъя.

**С.Ганбаатар:** Аж үйлдвэржилт гэдэг бол Монгол оронд хамгийн чухал юм бол ерөөсөө л аж үйлдвэржилт байгаа. Энэ бол 2020-2024 онд анх байгуулагдсан Байнгын хороо. Тэгээд анхны дарга нь бол манай Эрчим хүчний сайд Чойжилсүрэн гишүүн байгаа. Тэгэхээр дэд бүтцийн асуудлууд бүгдээрээ Эдийн засгийн байнгын хороонд харьяалагдаж байгаа. Одоо энийг яаралтай Засгийн газрын хуралдаан болон энэ Улсын Их Хурлын бүтэц зохион байгуулалтын талаарх хуулиуд орж ирэхэд энэ дэд бүтцийн асуудлууд хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэр, барилгажилт, зам тээвэр, энэ аж үйлдвэрээс салгахын аргагүй зүйлүүд. Тэгээд энэ Аж үйлдвэрийн байнгын

хороонд энэ асуудлууд нь эхлээд оруулах тийм санал байгаа. Өөрөөр хэлбэл Лувсанжамц гишүүний байр суурьтай бүр санал нэг байна. Хүний нөөцийн асуудал аж үйлдвэржилтийн хамгийн чухал асуудал. Хүний нөөц. Энэ асуудлыг бас энэ яг Байнгын хороонд бүрэн хариуцуулж чадаагүй байгаа. Ачаа үүрье гэвэл хариуцлагаа бас бүрэн авах ёстой. Энэ дээр санал нэг байна.

Инновац, тэгээд дээр нь аж үйлдвэрлэлд буюу жижиг, дунд бизнес эрхлэгч болон хүнд, хөнгөн үйлдвэрлэлүүдэд зах зээл нээж өгөх тал дээр бас манай Байнгын хороо онцгой анхаарах ёстой. Зах зээлийг нь нээж өгөх гадаад зах зээл, дотоод зах зээл бүгдээр энэ тендерүүд бүгд хаагдмал, бугимал байдалтай байгаа. Энэ зах зээл нээх ажлуудыг ил тод болгож, энэ Байнгын хороо хамгийн гол нь бизнес эрхлэгч нартай л тулж ажиллах ёсто. Бизнес эрхлэгч нарыг төртэй хэлэлцээрийн ширээнд суулгадаг үндсэн зорилго нь байх болов уу гэж би бодож байгаа. Тэгээд хуулийн хүрээнд ажиллана. Байнгын хорооны эрх хэмжээг тэлэх аж үйлдвэржилт гэж нэгэнт ажлын байр, жижиг дунд, хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэр гээд 3 том салбарын үйлдвэрүүдийг хариуцаж байгаа бол Лувсанжамц гишүүний энэ саналуудыг бас ажил хэрэг болгож ажиллах ёстой. Миний байр суурь санаа бол хариуцлагуудаа бас энэ чиг үүрэгтээ бас тодорхой оруулах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Дараагийн асуулт асуух гишүүн хэн байлаа. Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

**Д.Энхтүвшин:** 2 асуулт байна. Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт бас аж үйлдвэржилттэй холбоотой нэлээн олон заалтууд байгаа. Тэгэхээр жишигээлбэл зэсийн үйлдвэр ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ дээр яах вэ нэг талаасаа тийм байна. Нөгөө талаасаа бас төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг 25

хувиас хүргэнэ гэсэн ийм заалт байгаа юм. Тэгээд өөрөөр хэлбэл энэ аж үйлдвэржилтийн өсөлтүүдийг болохоор төр гэхээсээ илүү тэгэхээр төсвийн урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал, цэвэр зээл гэсэн үзүүлэлтүүдийг бүгдийг нь хязгаарлахаар ийм юм харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хөрөнгө оруулалтын зардал ч гэсэн нэлээн буурахаар. Тэгэхээр энэ том том хөрөнгө оруулалтын төслүүдийг хувийн хэвшлийн санаачилгаар л явахаар тийм дүр зургууд харагдаад байгаа. Тэгэхээр төрийн эзэмшлээр хийх хэд хэдэн том төслүүд энэ дотор явж байгаа. Тэгэхээр энэ аж үйлдвэржилтийг хувийн хэвшлийн оролцоог давамгайлсан энэ бодлогыг яаж харж байгаа вэ. Энэ төрийн бас том төслүүдийг бас үргэлжлүүлэх талаар ямаршуу бодолтой байгаа вэ гэдгийг нэг асуумаар байна.

2 дугаарт нь Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих асуудал бас яг энэ Байнгын хорооны асуудал байгаа. Тэгээд энэтэй холбоотой холбоотой асуудал тэр Засгийн газрын бүтэц дээр өмнө нь ч гэсэн Хөдөө аж ахуйн яаманд энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг хариуцуулдаг. Тэгээд тэндээ болохоор илүү хөдөө аж ахуйн л асуудал ярьдаг болохоос яг жижиг дундтай холбоотой асуудлыг жишээлбэл тэнд бол ийм дагавар хүүхэд шиг ийм байдалтай явдаг. Тэгэхээр энэ байдал дээр та энэ яамны бүтцийг яаж харж байгаа вэ. Энэ жижиг, дунд үйлдвэрлэлтэй холбоотой асуудлуудыг Хөдөө аж ахуйн яаманд байгаа. Тэгээд энэ жижиг дундтай холбоотой дэмжих асуудлыг та ямархуу байдлаар дэмжинэ гэсэн тийм бодол төлөвлөгөө, санаа оноо байгаа юу. Тэр талаар асуух гэсэн юм.

**С.Одонтуяа:** Нэр дэвшигч Ганбаатар гишүүн хариулъя.

**С.Ганбаатар:** Энхтүвшин гишүүн маш чухал өнцгүүдийг бас гаргаж тавилаа. Миний бодлоор бол Ардын намын мөрийн хөтөлбөр, Ардчилсан

намын мөрийн хөтөлбөр дотор ч байгаа. Ер нь том том үйлдвэрлэлүүдээ хөгжүүлбэ гээд. Энэ дээр бол өнгөрсөн 30 жилийн хамгийн том алдаа гэвэл сайд нар Засгийн газар өөрийгөө энэ дэлхийн хамгийн ухаантай хүмүүс гэж боддог. Эд нар ерөөсөө л ханцуй шамлаад л би яадаг юм үйлдвэр хөгжүүлээдэхье л гээд дайраад байдаг. Энийг надаас илүү хэн шийдэх вэ, энийг надаас илүү хэн шаналдаг вэ, туршлагатай вэ гэж өөрсдөөсөө асуудаггүй. Тэгэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны үндсэн зорилго бол энэ хувийн хэвшилд буюу гадаад дотоодын хөрөнгө оруулагч нар бизнес эрхлэгч нарыг төртэй хамтарч яаж шийдэх вэ гэдэг гарц гаргалгаа дээр яах вэ Солонгост бол улсын 3 талт хэлэлцээр, эдийн засгийн 3 талт хэлэлцээр гэж явж байгаа. Нийгэм өөрөө ордог. Япон ч гэсэн Ли Ку Яан ч гэсэн дээ яг ажил олгогч, бизнес эрхлэгчдийн төлөөллийн байгууллага нь яам шигээ яг ингээд Засгийн газартаа суудаг. Манайхан бол ерөөсөө алгасаж хаячихдаг. Тэд нар нь тэгээд сайд нарын гэрийн гадаа юм өгөх гээд очерлож байдаг. Энэ тэнэглэлийг зогсоохын тулд Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо бизнес эрхлэгчид буюу энэ томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч нартай ерөөсөө л 5 бодлогоор 5 бодлогоор зах зээлээ яаж тэлэх юм. Инновац технологийг яаж шингээх юм. Хүний нөөцийг нь яаж бэлдэх юм. Энэ олон их, дээд сургуулиуд чинь зүгээр улс төрийн бялуу аваад нэг захирал царайлаад суухгүй, энэ бизнес эрхлэгч нарт боловсон хүчнийг нь бэлдэж өгье гээд улсаас мөнгө авч байгаа хүмүүс шүү дээ.

Тэгээд дэлгэрүүлж яриад яах вэ. Би товчхон хариулъя. Маш чухал асуулт. Энэ дээр бол бид хувийн хэвшлийг хамтарч хэрэгжүүлэх гүүр, хаалга, боломж нь энэ Байнгын хороо болно гэж ойлгож байгаа. Яагаад гэвэл Байнгын хорооны үндсэн 3 эрх байгаа шүү дээ. Хууль танилцуулах. Тэр мега төсөл хэрэгжүүлэх гэж байгаа бизнесменүүдэд

хууль, эрх зүйн орчныг нь танилцуулах, болохгүй байгаа юмыг нь засах, *investigable* гэж яриад байх шиг байна. Мөрдөж шалгаж хариуцлагыг нь тооцох. 3 дугаарт болохгүй байгаа юмыг нь хуульд бид нар оруулах. Бид чинь хуульд өөрчлөлт оруулах эрхтэй хүмүүс шүү дээ. Тэрнээс өөрсдийнхөө санаачилгаар биш. Тэр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гээд байгаа бизнес эрхлэгчдийн зовлонг хуульд оруулна гэж бид энд сууж байгаа.

Тэгээд түрүүн яамны бүтцийг 2 дугаарт нь асуулаа. Яамны бүтэц дээр бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам гээд байгаа. Уул уурхайг бол хүнд үйлдвэрээс заавал салгах ёстой. Энэ 2 өөр функцийг нэг дор аваачаад хаячихсан. Хүнд үйлдвэрийг бол бүр шал өөр зүйл байхгүй юу. Уул уурхайгаас өөр зүйл. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр гэж байгаа юм. Хөнгөн үйлдвэр бол бүр тусдаа зүйл. Хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэр 2-ыг бол харин Үйлдвэрлэлийн яам байгуулаад манай дор байлгавал Монгол орон цэнгэлийн манлайд хүрнэ гэж би итгэдэг. Тэгээд ийм сайхан асуулт асуусанд би бас бодож явдаг зүйлээ ярих боломж олдлоо. Тэгээд энийг яах вэ, томхон юм руу дайрах юм бол хэлээ унжуулчихаж магадгүй. Тэгээд бид нэг би чинь 1 жил байна уу мэдэхгүй байна. Богинохон хугацаанд л байгаа байх. Тэгээд энэ хооронд үр дүн гаргах юмаа хамт олонтойгоо хэрвээ зөвшөөрөгдвөл ярих байх. Тэгээд ийм байр суурьтай байгаагаа илэрхийлье.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Одоо Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

**Д.Батбаяр:** Надад 2 асуулт байна. Маш тодорхой 2 асуулт.

1 дүгээрт нь Эрдэнэтийн зэсийн баяжмалыг боловсруулах, баяжуулах үйлдвэрээс гарсан түүхий эдийг хайлах ямар боломж байна. Ер нь та сая хэллээ. Уул уурхайгаас бол тусдаа асуудал гэж. Харин ч яг жинхэнэ холбоотой асуудал учраас Хөвсгөлд байгаа энэ Бүрэнхааны

ордыг ашиглаад зэс хайлах үйлдвэр барих боломжтой гэж та үзэж байна уу. 1 дүгээр асуулт нь. Эрдэнэт үйлдвэрээс гарсан баяжмалыг Хөвсгөлийн Бүрэнхааны ордоос гарах фосфороор энэ 2-ыг ашиглаад зэс баяжуулах үйлдвэр барих боломж байгаа юу. Та энэ дээр ямар байр суурьтай байна.

2 дугаарт нь 5 дугаар бүс буюу Төв, Дархан, Сэлэнгэ бол миний бодож байгаагаар үйлдвэрлэлийн гол район гэж боддог. Дүүрэг гэж үздэг. Ер нь бол үйлдвэр гэдэг юмаа түүхий эд дээрээ үндэслэж босож байгаа юм. Түүхий эд байхгүй бол хэчнээн үйлдвэр босохгүй. Инновац энэ тэрийг нь бол зүгээр худалдаад оруулаад ирчхэж болдог учраас. Тэгэхээр 5 дугаар бүсэд ямархуу үйлдвэр байх боломжтой вэ. Хөдөө аж ахуй болон уул уурхайн, барилгын материалын үйлдвэр байх боломжтой гэж та бодож байна уу. 5 дугаар бүс буюу Дархан, Сэлэнгэ, Төв аймагт.

**С.Одонтуяа:** С.Ганбаатар гишүүн хариулъя.

**С.Ганбаатар:** Би товчхон хариулъя. Далайн Батбаяр гишүүний асуултад хариулъя. Зэс хайлах үйлдвэр өнгөрсөн 4 жил их яригдсан. Туйлаас би дэмжиж байгаа. Ганцхан ТЭЗҮ дээрээ бид нар ерөөсөө ярьдаггүй. Оюутолгой гэдэг юмыг бол би хэзээ ч эсэргүүцээгүй. Ганцхан ТЭЗҮ болон гэрээний зүйл, заалтаа Монголчууд нэг ч ярьдаггүй. Фантази. Аймар гоё болно гээд л гуяаа алгадаад байдаг. Деталь дотор чөтгөр байдаг гэж ерөөсөө бид мартдаг. Тэр шиг өнгөрсөн 4 жилд зэс зайлах үйлдвэрийг нэр усыг нь яриад яах вэ. Хөөрхий ингээд лоббичид орж ирээд байгуулсан. Жилдээ 15 тонн тэр шар нунтаг хорттой бодис Эрдэнэтийн үйлдвэрийн тэр ууршаад, дээр нь тэр сайхан байгаль байхгүй болох байгаль орчны дүгнэлт гарсан. Тэрийг би асууж байсан. Энийгээ яаж багасгах вэ. Ерөөсөө эсэргүүцээгүй шүү дээ. Энийг



ТЭЗҮ дээр заавал ярьж байж үйлдвэржилтээ хийхгүй бол болохгүй.

2 дугаарт. Эдийн засгийн тооцоо судалгаагаар өнөөдөр би бүр нарийвчилсан тоог нь яриад яах вэ, тонн тутам үйлдвэрлэлийн зардал нь хэд вэ. Эдийн засгийн дүгнэлтээр ярих юм бол 8 жилийн хугацаанд 700 сая долларын хөрөнгө оруулалт хийгээд, 370 сая долларын алдагдалд орохоор ТЭЗҮ гарч ирсэн. Энэ болгоныг би тодруулж асууж байсан нь нэг их эсэргүүцэж байгаа юм шиг болчхоод байдаг. Тэгээд бид нар бүгдээрээ дэмжинэ. Ганцхан ТЭЗҮ дээрээ техникийн, түрүүн Энхтүвшин гишүүний маш чухал асуултад би бас дутуу хариулсан байна шүү. Далайн Батбаяр гишүүний асуултад хариулчихъя. Улс төрчид ухаантай царайлж үйлдвэрлэл байгуулна гэж бүгдээрээ мөрөөдөж болно. Хүсэж болно. ТЭЗҮ буюу бие даасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргаж, дүгнэлтээ тойрч бид ярихгүй бол бүгдээрээ Оюутолгой шиг бүгдээрээ дампуурал руу орно гэдэг байр суурийг илэрхийлээд товчхон хариулбал зэс баяжуулах үйлдвэр шиг чухал юм байхгүй. Тэгэхдээ гадаад эдийн засгийн буюу Хятад бол энэ дээр бүр алдагдалтай ажиллаж байгаа шүү. Би нарийн тооцоог нь энд ярьж цаг үрээд яах вэ. Эдийн засгийн тооцоолол, үр дүн, ТЭЗҮ-г бие даасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтийг тойрч бид яриад, ТЭЗҮ-ээ сайн боловсруулаад урагш нь зүтгүүлэх ёстой гэсэн байр суурьтай байдаг.

2 дугаарт бол 5 дугаар тойрог буюу манай Дархан. Би урьд нь бас сонгогдож байсан. 5 дугаар тойрогт Дархан, Төв аймаг орж байгаа. Сэлэнгэ орж байгаа. Тийм ээ. Энэ 3 аймаг дээр бол үйлдвэрлэл үнэхээр чухал. Тэгэхдээ яг зэс хайлах үйлдвэрийн тал дээр бол говийн бүсэд Говьсүмбэр аймаг болон 2, 3 ч ТЭЗҮ хийгдчихсэн төсөөллүүд явж байгаа. Зүгээр алинаар нь ч бай бид дэмжих ёстой. Ганцхан бие даасан хөндлөнгийн

шинжээчийн дүгнэлтийг бид тойрч ярих ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Одоо Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууна. Дараа нь үг хэлэх бас боломж байгаа.

**Л.Мөнхбаясгалан:** Мөн ч том Байнгын хороог ахлах боллоо. Мөн ч их асуудлыг нуруу дээрээ үүрч, их амаргүй ачаа үүрч байгаа таныг дэмжинэ. Энэ Дарханы арьс ширний үйлдвэр гээд нэг мөнхийн сэдэв байна. Хийж байгаа хүнийг нь баривчлаад шоронд хийчихдэг. Ер нь сүүлийн 20 гаруй жил Монголд аж үйлдвэржилт ярьсан, аж үйлдвэрийг дэмжсэн, үйлдвэржилт ярьсан болгоныг шорон, цагдаа, нэр төрийг нь гутаадаг нэг ийм ажиллагаа явагддаг болсон. Монгол Улсыг зөвхөн импортын орон байлгах сонирхолтой.

1 дүгээр асуудал. Малчид орлогогүй байна. Өвөл зудад малаа барсан малчид банкныхаа өрийг дарахын тулд Солонгост ажил хийхээр эсвэл уурхайд очиж ажиллахаас өөр аргагүй болж байна. Тэгсэн хэр нь 70 сая малтай. Сүүнийхээ 90 хувийг импортлодог ийм л улс болж хувирсан. Тэгэхээр малчдад зориулсан, малчдыг орлоготой болгох, малын гаралтай түүхий эдийг боловсруулах тал дээр та ямар бодлого барьж ажиллах вэ.

Жижиг, дунд үйлдвэрлэгч нар үнэхээр энэ улсыг нуруун дээрээ үүрч явах ёстой хүмүүс. Энэ хүмүүс их зээл авдаг, зээлээ төлж чаддаггүй дампуурдаг. Ажил хийх тусмаа өрөнд ордог. Өрнөөс өрний хооронд амьдардаг. Сүүлдээ энийгээ хаяад бас л гадагшаа ажиллах хүч болж гарч байна эхнээсээ. Тэгэхээр энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж та ямар ажил хийх вэ. Том, хүнд үйлдвэрүүдийн тал дээр бол та өөрөө мэдэх байх даа. Сайншиандын аж үйлдвэрийн цогцолбор 15 жил яригдлаа. Манай тойрогт байдаг. Говийн бүсэд бол мэдээж том том үйлдвэрүүд

ашиглалтад орох ёстой. Төрөөс дэмжсэн бодлого нь байдаггүй, аль болохоор гацаадаг. Аль болохоор нэр хүндийг нь гутаадаг. Шорон цагдаагаар далайлгадаг. Энийг бас болиулахын тулд та ямар бодлого баримтлах вэ. 3 асуулт асуулаа.

**С.Одонтуяа:** Нэр дэвшигч С.Ганбаатар гишүүн хариулъя.

**С.Ганбаатар:** Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Дарханы аж үйлдвэрийн парк 1 дүгээр асуулт. Энэ дээр бол тэр 3 дугаар асуулттай бас таарч байна. Сайншандын аж үйлдвэрийн парк яагаад гацав. Ер нь яаж урагшаа явуулах вэ гэж байна. Бүлэглэлүүд буюу улс төрчид энийг яаж явуулах вэ гэж шийдвэр гаргаж, техникийн шийдвэрүүдийг гаргах юм бол ер нь нэг үг бий л дээ. Техникийн асуудлыг улс төрчид шийддэггүй юм гэж нэг үг бий. Техникийн асуудлыг шинжээч, экспертүүдийн дүгнэлтийг тойрч ярина. Тэрэнд аль нам нь аль бүлэглэл нь хамаагүй улс төрчид захирагдах ёстой. Тоо бол тоо л байдаг. Техникийн инженерийн асуудлууд инженерийн асуудлууд байдаг. Тэгэхээр яг энэ Дарханы аж үйлдвэрийн парк болон Сайншандын аж үйлдвэрийн паркууд дээр бүлэглэлүүд 2 тийшээ олон тийшээ татаж чангааж байгаа бол тэд дандаа эрх ашгаараа ярьдаг. Тэгвэл бие даасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргаад, тэрийгээ тойрч энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороо дээрээ яг тэр инженер болон экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслээд урагшаа явахаас өөр ганцхан арга зам юм. Энэ олон улсад ч байдаг арга зам. Үүгээр явуулж энэ олон гацаатай улс төрчид болон бүлэглэлүүдийн ашиг сонирхлын хэрээсэнд орчихсон байгаа төслүүдийг урагшлуулах хүсэл сонирхол байгаа. Тэгэхдээ би ч ер нь хурал удирдаж зохион байгуулдаг л төдий хүн шүү дээ. Тэгэхээр та нартайгаа хамтрах сонирхол их байгаа гэдгээ илэрхийлье. 1 дүгээр зүйл. Дарханы аж үйлдвэрийн парк гэдэг бол

олон олон бизнес эрхлэгчдийг бас урагшлуулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх тийм боломж учраас энэ урагшаа явах ёстой.

Малчид орлогогүй байна. 70 сая малтай гэж байна. Яг нарийн яривал манайх бол хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн бодлого бол манайх маш муу. Алдагдчихсан. Ичмээр шүү дээ. Манайх чинь ер нь жилдээ 4-5 сая үхэртэй шүү дээ бойлоод л 4 сая болно. Тэгээд өсөөд 1 5 жоохон гарна. Тэгэхэд Хятад 70 сая үхэртэй шүү дээ. Австрали 70 сая үхэртэй. Бразил хамгийн их, 214 сая үхэртэй. Өнөөдөр бид чинь мал аж ахуйн орон гэж хэлэхээсээ илүү мал аж ахуй дээрээ онцгой анхаарах орон болчихсон гэдгийг л илэрхийлж, энэ дээр бас би дахиад л хэлье. Миний бодлого олон дахин шинэ шинэ бодлого гаргахгүй. Манай малын гаралтай түүхий эдийг боловсруулаад, экспортод гаргаж байгаа, технологийн шийдлээ олчихсон, экспортынхоо контрактуудаа олчихсон байгаа олон олон сайн компаниуд явж байгаа жижиг дунд. Тэрийг яаж экспанд хийж, яаж бусдад нь нялзааж, яаж бусдад нь хүртээлтэй болгох вэ гэдэг нь манай бодлого. Тэгэхгүй өөрсдөө шинээр бүх юмыг зохиогоод байхаас илүү байгаа шинэ сайн практикуудыг л дэлгэрүүлэх явдал бол 1 дүгээр ажил. Шинээр юм зохиохоос илүү. Малчдын энэ орлогогүй байдал бол үнэн тулгамдаж байгаа асуудал. Тэгээд Мөнхбаясгалан гишүүн бол яг оночийг нь олж хэллээ.

Өрөнд орсон гэж байгаа үнэн. Яагаад вэ гэвэл өнөөдрийг хүртэл хүнс, хөдөө аж ахуй малчдад зориулсан энэ зээлийн бодлого, мөнгөний бодлогууд бүгд эзэндээ очдоггүй. Энийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих 7 сан байгаа шүү дээ. Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан, Орон нутгийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сан, Хориоо хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гээд. Энэ сангуудыг бүгдийг нь энэ жижиг, дунд бизнес эрхлэгч болон худалдаачдад нээлттэй, ил тод улирал болгон ярьдаг

байх ёстой хуулиа хэрэгжүүлдэггүй. Энэ Байнгын хороо хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж аймаг болгон, дүүрэг болгон руу явах ёстой гэж би ойлгож байгаа. Энэ бол чухал асуудлыг хөндлөө.

2 дугаар асуултад жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд яаж хөгжүүлэх вэ гэж байна. Зах зээл нээх хамгийн гол юм. Өнөөдөр нэг Дондог, Дулмаа гэдэг жижиг дунд бизнес эрхлэгч Япон, Хятад, Солонгос руу тэр эсгий гутал юм уу, арьсан бээлий юм уу ямар нэгэн жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн авдар юм уу хийгээд, тэрийгээ зарах гээд явдаг шиг зүйл байхгүй. Лукашенко Монголд ирээд ярьсан 2 юмны нэг нь манай тракторуудыг аваач л гэж байгаа юм шүү дээ. Энэ Засгийн газар хоорондын хэлэлцээр. Бүс нутгийн хоорондын хэлэлцээр. Дэлхийн худалдааны байгууллалтын гэрээнүүд яагаад энэ Монгол оронд ерөөсөө хэрэгждэггүй юм бэ. Засгийн газар болон энэ улс төрчид нь үндсэндээ зах зээлийг нээх ёстой ажлаа үндсэндээ хийдэггүй. Баян орны 2 орон уулзаж байгаа юм шиг л ухаантай царайлж баахан найрлаж найрлаж байгаад л салчихдаг. Энэ тэнэглэлийг зогсооход манай энэ Байнгын хороо бас нэг жсоохон ажиллах ёстой болов уу гэж би ойлгож ярьж байгаа.

3 дахь асуулт нь Сайншандын аж үйлдвэрийн парк яаж явуулах вэ. Шинжээчийн дүгнэлт. Хамгийн түрүүнд олон улсын болон үндэсний хэмжээний энэ чинь бид нэг талд бэлчдэг ямар ч эрдэмтэн судлаачгүй нэг тийм 3 сая 400 мянган, 500 ч билүү мянган хүмүүс биш шүү дээ. Шинжээч, эрдэмтдийн дүгнэлтийг эхэлж гаргах явдал бол манай Аж үйлдвэрийн байнгын хорооны 1 дүгээр ажил. Би хэрвээ Монгол орны Ерөнхийлөгч байсан бол ийм ажлыг хийх байсан. Ерөөсөө хийдэггүй л дээ эд нар. Тэгэхээр би энэ байр сууриудаа давтан давтан ярьж байгаа нь үүнээс өөр юмыг дэлхий олоогүй гэж би ойлгодог. Тэгээд маш чухал асуултуудыг асуулаа. Би бас

сэтгэлээ нээж ярих боломж өгсөнд баярлалаа.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Мөнхчулууны Энхцэцэг, Энхтуяа, Үүрийнтуяа, Энхтүвшин, Пунсалмаа, Золжаргал, Очирбат, Батбаяр нараар тасаллаа. Батбаяр гишүүнээр тасаллаа. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн үг хэлнэ.

**М.Энхцэцэг:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд. Би эрчим хүчний инженер хүн. Тэгээд энэ Аж үйлдвэрлэлийн байнгын хороонд орж байгаадаа маш их баяртай байна. Та бүхэнтэйгээ энэ 4 жил хамтраад тодорхой хэмжээний үр дүнд хүрчихсэн байх байх гэж итгэж байна. Бид нар өнөөдөр ярьж байгаа эрчим хүчний салбарыг бол түрүүлэн хөгжүүлж байж энэ бүх яриад байгаа бүтээн байгуулалтын ажлуудыг хийх боломжтой болно. Тэгэхээр том чадлын цахилгаан станцуудыг та бүхэн мэдэж байгаа. Энэ бол яалт ч байхгүй том үйлдвэрийн газар маш их хэмжээний ажлын байрыг бий болгодог. Тэгээд дулаан цахилгаан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, дээрээс нь энэ том цахилгаан станцуудын бүтээгдэхүүн нь борлуулах нь баталгаажсан. Тухайлбал та бүхэн мэдэж байгаа Тавантолгойн цахилгаан станцын цахилгааныг худалдаж авъя гээд Оюутолгойтой бид нар гэрээ хийчихсэн. Одоо 1квт цагийг 10.0 хэдэн центээр худалдаж авна гээд. Өөрөөр хэлбэл хэрвээ бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх юм бол би худалдаж авъя гэдэг зах зээл нь баталгаажчихсан. Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байна гэхээр өнөөдөр бид нарын энэ Аж Үйлдвэржилтийн байнгын хорооны нэг том анхаарал хандуулж ажиллах ёстой гол юм бол энэ том цахилгаан станцууд буюу энэ үйлдвэрүүдийг энэ бол нэг л төрлийн үйлдвэр. Тэгэхээр энэ үйлдвэрүүдийг барьж байгуулах тал дээр бид нар бас тодорхой хэмжээний хүчээ зориулж ажиллах ёстой гэж ингэж би бодож байна. Тэгээд энэ том чадлын

үйлдвэрүүдийг бид нар яагаад өнгөрсөн хугацаанд барьж чадахгүй байсан бэ гэдэг дээр маш олон асуудлууд тулгарч байгаа. Ялангуяа жишээ нь бол тендерийн хууль байж байгаа. Тавантолгойн станцыг бол тендерийг нь зарлаад бас маргаан гараад гээд л ингээд л дахиад л 1 жилээр, 2 жилээр гээд эргээд харахад бид нар 4 жилээ өнгөрөөчихсөн сууж байна. Тэгэхээр 4 жилийн дараа энэ Байнгын хороо маань тодорхой хэмжээний ажлуудыг хийчихсэн, үр дүнтэй сууж байх юм бол энэ том цахилгаан станцуудыг барьж байгуулахад бид нар бас тодорхой хэмжээний хувь нэмрээ оруулж ажиллах нь зүйтэй байх гэж би ингэж бодож байна.

**С.Одонтуяа:** Баярлалаа.  
Доржзодовын Энхтуяа гишүүн үг хэлнэ.

**Д.Энхтуяа:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Ингээд Байнгын хорооны даргад нэр дэвшиж байгаа нэр дэвшигчид амжилт хүсье. Би Байнгын хороодоос энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороог бас сонгож саналаа өгсөн нь бол манай Монгол Улсын хөгжилд бол маш том үүрэг рольтой ийм Байнгын хороо байх юм болов уу гэж бодож байна. Би 2 санаа хэлмээр байна.

Өнөөдөр аж үйлдвэржилтийг хөгжүүлэхэд бид нар ямар нэгэн байдлаар хөдөө аж ахуйн бодлогыг дэмжсэн, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогуудыг гаргадаг. Зээл тусламжийг ч гэсэн бас өгдөг. Хөнгөлөлттэй зээл тусламж өгдөг. Харамсалтай нь тэр зээл тусламжийг аваад, үйлдвэрлэлээ явуулаад, тэгээд үйлдвэрлэгчид маань 1, 2 жилийн дараа дампуурах хэмжээнд хүрчхээд байна. Тэгэхээр энэ дээр бол кластерын үйл ажиллагааг бол манай Байнгын хорооноос маш сайн дэмжиж өгмөөр санагддаг. Тодорхой нэг салбарт болон газар зүйн байршилд хоорондоо харилцан хамааралтай энэ бизнесийг дэмжих бодлогыг энэ Байнгын хорооноос, төрөөс

гаргаж өгөх ёстой юм шиг санагддаг. Яагаад ингэж вэ гэхээр бид нар бас зөндөө олон туршилагуудыг гадаадад очоод судлаад явдаг. Урд хөршид бол жилдээ 30, 40 сая хүнийг ядуурлаас гаргаад жижиг, дунд бизнес хөгжүүлээд ингээд явсан. Гэтэл 2, 3 жилийн дараа дахиад нөгөө бизнесийн зээл авсан төрийнхөө хөнгөлөлттэй зээлд хамрагдсан үйлдвэрлэгчид маань дампуураад буцаад ядуучуудынхаа эгнээнд очоод байсан. Тэгээд энэ юунаас болсон юм бэ гэхээр яг энэ кластерыг, хоорондын сүлжээг хийж өгөөгүйгээсээ болоод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулж чадахгүй эргээд ядуучуудын хэмжээнд очих ийм эрсдэл гараад, ийм үр дүн тайлан гарсан юм байна лээ. Тийм учраас энэ кластерын үйл ажиллагааг маш сайн төрөөс нь дэмжиж өгсөн. Тийм учраас жижиг дунд бизнес эрхэлдэг хүн байлаа гэхэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь байнгын хүлээн авагчтай, байнгын худалдан авагчтай, тэгээд их бага хэмжээгээр сар болгон тогтмол орлоготойгоо байгаа учраас тэр үйлдвэрлэл тогтмол тогтвортой явах ийм боломжоор нь хангаж өгөөд, тэгээд нөгөө ядуурлаас гарах, тэгээд энэ жижиг дунд бизнес дампуурахгүй байх энэ орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм байна лээ. Тэгэхээр энэ Байнгын хорооноос бас энэ бодлогыг гаргаж өгвөл бас дөхөмтэй болов уу гэж ингэж бодож байна. Тэгээд энэ дээр бол та бас дэмжиж өгөөрэй.

2-т нь манай энэ аж үйлдвэржүүлэлтийн үйлдвэрийн салбарын боловсон хүчний асуудал бол маш хэцүү. Энэ боловсон хүчний асуудал дээр яг нарийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх асуудал дээр бас тодорхой бодлого гаргах ёстой гэж би бодож байна. Ганцхан жишээ хэлэхэд жишээлбэл би нийслэлийн төлөөлөгчөөр ажиллаж байгаад ирлээ. Тэгээд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод метро байгуулна гээд л тэгж байна. Тэгэхэд өнөөдөр бол метроны тэр барьж байгуулах, тэгээд дараа нь засвар

үйлчилгээ хийх, зүгээр энгийн жишээгээр хэлэхэд метроны жолоочид нийтийн тээврийн жолооч гэдэг чинь зүгээр нэг машин барьдаг хүн барьдаггүй. Тусгай нарийн мэргэжлийн тэр бүх юмаа ингээд бэлддэг. Тэгээд энийг бол Герман ч юм уу, хөгжсөн орнуудад нарийн мэргэжлээр эзэмшүүлдэг. Тийм учраас энэ залуучуудаа нарийн мэргэжил эзэмшүүлэх яг энэ аж үйлдвэржилтээ хөгжүүлэх л гэж бодож байгаа юм бол энэ рүү чиглэсэн энэ салбарын нарийн мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй орнуудад бэлтгэх маш шаардлагатай байгаад байгаа.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Баярлалаа. Дараагийн Байнгын хороод орох гээд бас бид нарыг цагаа бариарай гэж байна шүү. Дараагийн үг хэлэх гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа.

**Д.Үүрийнтуяа:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Бодлогоор нэр дэвшиж орж ирж байгаа учраас би Ганбаатар гишүүндээ юуны өмнө амжилт хүсье. Аж үйлдвэржилтийн бодлого гэдэг бол Монгол Улсын хөгжлийн тулгуур ойлголт гэж би боддог. Бид эдийн засгийн өсөлтийг өрх бүрд хүргэнэ гэвэл Монгол Улс үйлдвэрлэгч орон болох ёстой. Тийм учраас энэ чухал бодлогын асуудлыг барьж байгаа хүний хувьд бас таны хариулж байгаа хариултауд дээр зарим зүйл дээр бас анхаараасай гэж хүссэн юм.

Тухайлах юм бол Эрдэнэтийн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр. Энэ үйлдвэр дээр таны ойлголтын зөрүү бас байгаад байна уу гэж би хараад байгаа юм. ТЭЗҮ одоо 7 сарын 17-нд тодотгол орно. Элементийн хүхэр үйлдвэрлэхээр ТЭЗҮ-д тусгагдсан. Цаашидаа бол элементийн хүхэр болон хүхрийн хүчлийн үйлдвэрлэл хамтдаа байхаар асуудлууд орж байгаа. Эдийн засгийн тооцоо судалгаа дээр бас таныг нягталж үзээсэй гэж хүсэж байна. Энэ бол бас Бүрэнхааны орд дээр хийгдсэн

ТЭЗҮ биш шүү дээ. Ер нь бол элементийн хүхэр үйлдвэрлэх Хятадын компанитай хамтарч хийсэн судалгааны ажлын үр дүнд хийж байгаа ТЭЗҮ явж байгаа. Тийм учраас би энэ аж үйлдвэржилтийн бодлого гэдэг бол бид нар улс төржүүлэх биш, харин технологийн шийдэл гарцыг мэргэжлийн хүмүүсээс практик дээр ажиллаж байгаа хүмүүсээс сонсож судалж энэ дээр шийдвэр гаргах ёстой шүү гэдгийг 1 дүгээрт хэлэх гэсэн юм.

2-т нь таныг би хэрвээ Байнгын хорооны дарга болоод ингээд ажиллалаа гэхэд энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихийн тулд том үйлдвэрийн газрууд нь жижиг, дунд үйлдвэрлэлээ дэмждэг бодлогыг ялангуяа Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулийн өөрчлөлтийг нэн тэргүүнд оруулж байж энэ бодлогын асуудал хувийн хэвшлийг хамтарч дэмжих асуудал яригдах байх. Энэ асуудал дээр бол бас санал санаачилга гаргаад ажиллана. Таныг дэмжиж ажиллаасай гэж хүсэж байна.

Бид нар энэ том үйлдвэрийн газрууд нь жижиг, дунд үйлдвэрлэлээ дэмждэггүй, тендерийн өндөр шалгуур босго тавьчихдаг. Өрхийн үйлдвэрлэгчдээ дэмждэггүй байж байж өнөөдөр үйлдвэржилтийг хөгжүүлэх тухай асуудлыг бол ярьж чадахгүй. Тийм болохоор нэн тэргүүнд том үйлдвэрийн төслүүдтэй зэрэгцүүлээд энэ анхан шатын гарааны бизнес эхэлж байгаа жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудлыг бол орхигдуулахгүй авч явах ёстой шүү гэдгийг би бас хэлэх гэсэн юм. Баярлалаа. Танд амжилт хүсье.

**С.Одонтуяа:** Энхтүвшин гишүүн үг хэлнэ.

**Д.Энхтүвшин:** Юуны өмнө энэ Байнгын хороо маань зөвхөн дарга гэхээсээ илүү Байнгын хороо маань дарга бол уялдуулж л ажиллах байх. Тэгээд бид хэдийн хувьд бол бас хэд хэдэн юман дээр анхаарах ёстой юм шиг санагдаж байна.

1 дүгээрт бол энэ байгаа хөрөнгө оруулалт хийчихсэн аж ахуйн нэгжүүдээ бас яг дэмжмээр байгаа юм. Тэгэхгүй бол одоо ер нь бол амыг нь барих, ер нь бол зогсоох л юм болж байна шүү дээ. Ингээд дансыг нь хаачихдаг. Жишээлбэл, зарим нэг компаниудын данс хаачихсан. Хэрэг шийдэхийн тулд аж ахуйн үйл ажиллагааг нь зогсоож явуулдаг юман дээр би аргаа олохгүй байна. Яг хаана нь очиж шийдэх ёстой юм. Бизнесийн тасралтгүй явах ёстой энэ хөрөнгө оруулалт чинь удаан хугацааны ийм үйл ажиллагаанууд байгаа. Тэгэхээр ингээд дампууруулах юмнуудаа эхнээс нь ингээд тавиад байгаа учраас байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаагаа тасалдалгүй явуулах, хэрэг асуудал байдаг бол тэрийг нь үйл ажиллагааг нь тасалдуулахгүйгээр явуулах энэ тал дээр бас идэвх санаачилгатай хэдүүлээ ажиллах ёстой юм байна гэж бодож байна. Тэгэхээр энэтэй холбоотойгоор бол сая би хэлсэн энэ өмчлөх эрхтэй холбоотой халдаж байгаа энэ асуудлууд, тэгээд гэнэт хуулиуд санаачилдаг. Жишээлбэл, хуулийг өөрөөр тайлбарладаг АМНАТ-тай холбоотой жишээлбэл асуудал байна. Энэ зах зээлийн үнэлгээг тогтоож байгаа асуудал дээр бол Сангийн яам болохоор нэлээн давамгайл байр суурьтай байгаад байдаг. Тэгэхээр энийг эргэж хармаар байна. Дээр нь аж ахуйн нэгжүүд энэ урт хугацаанд хөрөнгө оруулалт хийхдээ ашиг хөрөнгө оруулалтын тооцоонууд хийж орж байна. Тэгэнгүүт үнэ дээр нь жишээлбэл зохицуулалтууд тавьдаг, үнийг жишээлбэл тодорхой хэмжээг зах зээлийн бус байдлаар тааз тогтоодог, энэ үнийг нь зах зээлийн бус зарчмаар төрөөс энэ зохицуулалтууд хийж байгааг бас болиулмаар санагдаж байна. Тэгэхээр энэ одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг бас хэдүүлээ анхаарч, энэ тасалдалгүй явуулах дээр нь анхаарах ёстой гэж санагдаж байна.

Шинэ аж ахуйн нэгж хөрөнгө оруулалт аж үйлдвэржилттэй холбоотой асуудлууд дээр бол гол аж

ахуйн нэгжүүдийн хувьд бол тавьдаг 4 юм байна. Жишээлбэл, 1 дүгээрт бол энэ хөрөнгө оруулалт хийх сэдэл, татварын орчныг Хөрөнгө оруулалтын хуулиа бол бид хэд баталж чадаагүй. Өнгөрсөн парламент дээр хүлээлт байсан. Батлахгүй байна гэдэг нь өөрөө хөрөнгө оруулагчдад бол тэр таатай мэдрэмжид хүрэхгүй. Тэгэхээр энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийг илүү хөрөнгө оруулалтыг дэмжсэн, ялангуяа энэ хөрөнгө оруулалтууд гэхээр аж үйлдвэржилттэй л том хөрөнгө оруулалтууд байгаа учраас энэ чиглэлийн хөрөнгө оруулалтын хуулийг дэмжих чиглэлээр ажиллаасай гэж хүсэж байна.

2 дугаарт нь бол энэ зээлтэй холбоотой асуудлууд байгаа. Зээлийн хүү бол яг энэ үйлдвэржилтэд зориулсан хүү бас хязгаарлагдмал байгаа. Энэ тал дээр бас анхаарах ёстой байх. Тэгээд дараа нь бол энэ хүний нөөцтэй холбоотой асуудлууд байгаа. Хүний нөөц дээр хосмог сургалттай холбоотой асуудлыг Монгол Улсад нутагшуулах зайлшгүй шаардлага байгаа. Энэ дээр бас энэ аж үйлдвэржилтийн байнгын хороо маань бас нэлээн дэмжиж ажиллах ёстой санагдаж байна. Ажлын байран дээр нь хүмүүсээ бэлддэг. Танхимын сургалт гэхээсээ илүү яг ажлын байран дээр нь сургалт явуулж, шууд гараад ажиллах бололцоотой системийг нутагшуулах тал дээр ажиллах ёстой санагдаж байна. Дээр нь.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Баярлалаа. Одоо Пунсалмаа гишүүн үг хэлнэ.

**Б.Пунсалмаа:** Аж үйлдвэржилтийн байнгын хорооны дарга Ганбаатар даргадаа цаашидын ажилд нь амжилт хүсье. Аж үйлдвэржилт, худалдааны бодлого бол төрийн бодлого шийдвэрийн төвд байж байх ёстой. Уялдаа холбоотой ийм салбарууд байгаа. Бид нар үйлдвэрлэлийг хөгжүүлнэ, дэмжинэ гэдэг. Үйлдвэрлэлийг бол үйлдвэрлэж байгаа. Гэтэл тэр үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулах ийм

худалдааны томоохон төвлөрсөн институцийн бодлого алга байна. Худалдааны яам алга байна. Дэлхийн 205 орны 195 оронд өнөөдөр Худалдааны яамтай байгаа. Манайх энэ яам байхгүй байгаа болохоор та энэ тал дээр худалдан борлуулах энэ бараа бүтээгдэхүүнийг нь жинхэнэ баялаг болгох энэ зүйл дээр та илүүтэй анхаарч ажиллаарай гэж ингэж хүсмээр байна.

Цаашилаад манай Монгол Улсын төсвийн зарлага бол 27 их наяд төгрөг болсон. Тэрний ихэнх хувийг нь бид нар импортод зориулаад гадагш нь гаргачих ер нь шинжтэй. Энийг бол бид нар дотоодын үйлдвэрлэлдээ зориулсан квот тогтоогоод, үндэсний үйлдвэрлэгч нарыг бараагаар нь төрийн худалдан авалтаар дэмждэг байх хэрэгтэй. Энэ дээр квот тогтоогоод зарлах юм бол үйлдвэрлэгч нар тэр хэмжээнд нь зориулаад тоног төхөөрөмжөө бараа бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд ингээд маш олон үндэсний үйлдвэрлэл хөгжих боломж байгаа шүү. Тэгэхээр энэ төрийн худалдан авалт дээр цаашид анхаарч ажиллаарай гэж энэ бодлогын хорооны бүх гишүүддээ хүсье. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Одоо Золжаргал гишүүн үг хэлнэ. Уг хүмүүсийн овог, нэргийг нь хэлэх ёстой. Нэрийг нь сайхан цээжилнэ ээ.

**Ж.Золжаргал:** Ганбаатар даргад болон Байнгын хорооны гишүүддээ амжилт хүсье. Нэг хандлагын өөрчлөлтийг бүгдээрээ анхаараасай гэж бодож байна. Хувийнхаа бодлыг хэлье. Үйлдвэрлэлийг дэмжихийн тулд төрийн байгууллагууд ер нь байдлыг хараад байхад маш их төлөвлөгөө гаргадаг. Хаана ямар үйлдвэр барих вэ түүхий эдээ хаанаас авах вэ ингэнэ тэгнэ гээд зургийг нь зураад байрлалыг нь тодорхойлоод юу хийхийг нь ямар технологи ашиглахыг нь зааж өгнө гээд ингээд байдаг. Тэгээд түүгээр бол ер нь юм хэрэгждэг тийм түүх бараг байхгүй. Тэгээд би энэ салбарт бас ажиллаж байсан хүний

хувьд хэлэхэд төрийн дэмжлэг 1 дүгээрт хатуу дэд бүтэц, эрчим хүч, энэ барьчихсан төмөр замын суурь дэд бүтцээ яаж хүртээмжтэй бүгдэд нээлттэйгээр ашиглах вэ, тэгээд усан хангамж нөгөө гадаргын усыг ашиглана гэсэн тийм зорилт байдаг хэр нь тэрийг ашиглахаар илүү их ашигтай байна гэсэн зохицуулалт байхгүй. Үнийн бодлогын. Тиймэрхүү хатуу дэд бүтэц дээр 1 дүгээрт анхаарч өгөөрэй.

2 дугаарт нь эрх зүйн орчин буюу татварын зохицуулалт хэрэгтэй байна. Үйлдвэрлэл явуулахад. Ялангуяа экспортод гарч байгаа бүтээгдэхүүн ганц 2 жишээнүүд байна л даа. Зарим нь хаагдчихсан. Японд нарны хавтан үйлдвэрлээд Япон руу гаргадаг. Хөнгөн цагаан эдлэл авчирч зороод буцаагаад онгоцоор явуулчихдаг. Тэгээд эд нар ингээд өртөг өндөртэй учраас тэлж чадахгүй байгаа. Монголын үйлдвэрлэл буцаад нөгөө ажлын байр нэмэгдэнэ, цалингаа өгнө. Тийм болохоор тиймэрхүү юмнуудыг экспортод эцсийн бүтээгдэхүүн гаргаж байгаа бол татварыг нь бүр зоригтойхон шиг бууруулж өгөөд ингэж нэммээр байгаа юм. Одоогийн юунуудыг хараад байхад ашигт малтмал дээр бол жишээ нь зарим тохиолдолд амнатыг нь боловсруулахаар давхардуулаад тооцчихдог, эсвэл буцааж нөгөө хасалтаа хийдэггүй. Хаягдлыг боловсруулахаар АМНАТ нь боловсруулсан түүхий эдээр тооцогдоод өндөр болоод ашиггүй болчхоод байдаг энэ тэр тийм зохицуулалтууд нь аж үйлдвэрийн эсрэг үр дүнд хүргээд байдаг зүйлс байдаг.

Тэгээд эцэст нь дахиад хэлэхэд энэ тусгай сангууд үүсгээд зарим нэг төрлийн үйлдвэрлэлийг нь ингэж түүж авч байгаад дэмждэг. Яг тэрүүгээр нь тэр нь 1 нь онцгой дэмжлэг аваад нөгөөдүүл нь хоцордог. Тэрийг авахын тулд бас авлига явдаг. Улс төрчид нь холбогддог иймэрхүү юмнуудыг ер нь аль болохоор болимоор байна. Нийтээр нь

төрөөс яг юу хийж яаж үйлдвэрлэхийг нь заагаад байлгүйгээр дэд бүтэц, татварын орчныг нь сайжруулаад нийтээрээ л үйлдвэрлэл явуулахад хялбархан, ямдхан байхгүй.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Дараа нь Байнгын хорооны гишүүд бас сайхан хамтарч ажиллаж болох байх. Одоо Ганбатын Очирбат гишүүн үг хэлнэ.

**Г.Очирбат:** Байнгын хорооныхоо нийт гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд бодлогоор ямар ч байсан Ардчилсан намд энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороо өгсөнд хувь хүнийхээ хувьд их талархаж байна. Яагаад гэхээр Ардчилсан нам бол энэ 2024 оны сонгуульд орохдоо алдагдсан 8 жилийн алдааг засна гэж орж ирж байгаа юм. Доорх ганцхан шалтгаан бол энэ аж үйлдвэрийн салбараа бид нар өөд нь дээшээ нь татна, өнгөтэй болгоно. Энд ихэнх нь бас эдийн засагч хүмүүс сууж байгаа байх. Эдийн засгийн онолыг олон янзаар тайлбарладаг. Тэгэхдээ шавхагдмал нөөцөөр шавхагдашгүй хэрэгцээг хангана л гэж байгаа юм. Тэгэхээр бид нарын нөөц хаана байна гэхээр газрын доорх буюу газрын дээрх нөөц байгаа. Нөөцийг юунд ашигладаг вэ гэхээр аж үйлдвэрийн салбарт 1-д ашиглана, 2-т гэх юм бол боловсролын салбарт буюу хүмүүсээ бэлдэнэ, мал аж ахуйн салбар гээд ингээд явчихдаг. Тэгэхээр өнөөдөр ямар ч байсан Ардчилсан намаас Ганбаатар гишүүн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга болж байгаад маш их баярлаж байгаа. Тэгээд бид бас бүгдээрээ энэ хүнийгээ бас дэмжээд ажиллах ёстой байх гэж харж байна. Энэ чинь нэг л Монгол. Тийм болохоор хэдүүлээ энэ аж үйлдвэрийн салбар дээр дуугараад явна гэж бодож байгаа шүү.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбар, хүнд үйлдвэрлэлийн салбар 2-ыг мэдээж 2 янзаар ойлгоод байдаг. Маш хүнд юм авч байгаа. Ганбаатар гишүүн ээ та. Хүнд

үйлдвэрлэлийн салбар чинь өөр газар байгаа, хөнгөн үйлдвэрлэлийн салбар чинь өөр газар байгаа. Байнгын хороо гээд шинээр энэ чинь 2020 оны өмнөх парламентад үүсчихсэн. Тэгэхээр хэдүүлээ бас олон талаас нь нэлээн энэ Сангийн яамтай болон энэ Хүнс, хөдөө аж ахуйн яам, Уул уурхайн яамтай нэлээн хамтарч ажиллаж байж ажлаа урагшлуулахгүй бол болохгүй шүү. Та тэгэхээр тэр дээр negotiation-оо маш сайн хийгээрэй гэж хэлэх гэсэн юм.

Тэгээд Давхар танд бас Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийг сануулах гэсэн юм. Нэгэнт Ардчилсан намаас Байнгын хорооны дарга болж байгаа болохоор бид нар бол энэ аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэхдээ энэ гангийн үйлдвэр буюу энэ кластер маягаар том үйлдвэрүүдээ явуулаад жижиж, дунд үйлдвэрлэлүүдээ татаж авна гэдгээ та маш сайн ойлгох хэрэгтэй шүү. Тэгэхээр бид нар нөгөө том үйлдвэр явуулахын тулд том хөрөнгө оруулалтын асуудал яригддаг. Тэгээд том хөрөнгө оруулалтын асуудал яригдахаар бид нар гадна, дотнын жишээ нь Оросуудтай, Хятадуудтай асар их хоригтой бид бараг тулна. Тэгэхээр энэ дээр бас дипломат харилцаагаа ашиглаад аль болох олон талын эрх ашгийг хангасан маягаар та ажиллаарай гэж хүсэх гэсэн юм.

Ардчилсан намын мөрийн хөтөлбөр дээр бол энэ нэлээн олон энэ химийн поксжих үйлдвэрүүд ялангуяа энэ хар төмөрлөгийн үйлдвэр тэгээд төмөрлөгийн үйлдвэрийг дагасан кластер үйлдвэрүүд гээд олон юм орж ирсэн байгаа. Та мөрийн хөтөлбөрөө бас нэлээн сайн хараарай Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр дээр ч гэсэн аж үйлдвэрийн салбар дээр нэлээн юм орж ирсэн байна лээ. Тэгээд Ганбаатар гишүүндээ амжилт хүсье. Байнгын хорооныхоо бүх гишүүдэд амжилт хүсье. Монгол Улсын хөгжил бол манай Байнгын хороотой салшгүй холбоотой. Хүний нөөц дээрээ ч тэр, эдийн засаг



дээрээ ч тэр, ажил хийх дээрээ ч тэр бүх тал дээрээ холбоотой шүү. Тэгэхээр бүгдээрээ нягт, нямбай ажиллаж бас улс эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулцаа л гэж хэлэх гэсэн юм. Тэгээд амжилт хүсье Ганбаатар гишүүнд.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Далайн Батбаяр гишүүн үг хэлнэ.

**Д.Батбаяр:** Ганбаатар гишүүндээ амжилт хүсье. Тэгэхээр аж үйлдвэрийг бол хувийн аж ахуйн нэгжүүд л хийнэ. Бүтээн байгуулалтыг хувийн аж ахуйн нэгжүүд л хийх учраас дэмжиж ажиллах ёстой. Манай байнгын хороо ч гэсэн, Улсын Их Хурал ч гэсэн, Засгийн газар бүгдээрээ дэмжиж ажиллах ёстой. Тэгэхээр Улсын Их Хуралд санал, дүгнэлт оруулдаг, хяналтыг хийдэг, Улсын Их Хурлын нэрийн өмнөөс хяналт хийдэг институцийн хувьд хувийн аж ахуйн нэгжид ажил хийхэд амархан ийм орчныг бүрдүүлэх тал дээр л бүгдээрээ ажилламаар байна. Тэгээд энэ Байнгын хорооны даргын хувьд гишүүдтэйгээ нийлээд бүгдээрээ энэ тал дээрээ ажиллая гэсэн ийм л байна даа.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх санал хураалт явуулахын өмнө горимын саналаар санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.2-т ил санал хураалтыг цахимаар эсвэл гар өргөж хурааж болно гэж заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулах горимын саналыг хуралдаан даргалагчаас гаргаж байна. Ингээд энэ горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Гар өргөж явуулна. 100 хувь санал дэмжигдлээ. 100 хувийн саналаар гар өргөж явуулах горимын санал дэмжигдлээ.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад Сайнхүү овогтой Ганбаатарыг нэр дэвшүүлэхийг

дэмжье гэсэн томъёоллоор санал хурааа. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад Сайнхүү овогтой Ганбаатарыг дэмжье гэдэг санал 100 хувийн саналаар дэмжигдлээ. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батбаяр танилцуулчих уу. Далайн Батбаяр гишүүн танилцуулна. Ингээд Байнгын хорооны даргаар сонгогдсон Сайнхүүгийн Ганбаатар гишүүндээ ажилд нь амжилт хүсэж баяр хүргэе.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

10.20 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ